

## ЗҮҮН ХОЙТ АЗИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНД МОНГОЛЫН ОРОЛЦОО

**Х.ДАШДОНДОВ**

Зүүн хойт Ази /ЗХА/ нь хөдөө аж ахуйг /ХАА/ хөгжүүлэх арвин их нөөц бүхий асар удам газар нутагтай, байгаль цаг уурын тааламжтай нөхцөл, хүн ардын эрт дээр үеэс эрхлэн дадаж заншсан уламжлалт технологи, орчин үеийн техниктэй ч гэсэн “нийгмийн харилцааны ялгаа”, “хүйтэн дайны” сөрөг нөлөөлөлөөс болж, өнөөг хүртэл энэ бүс нутагт хамтын ажиллагааны нэгдмэл цогцолбор бүтэц бүрдүүлээгүй явж ирсэн нь бүс нутгийн улс орон, ард түмний чухал хэрэгцээг хүнсний болон ХАА-н гаралтай аж үйлдвэрийн барааг алс холоос импортлон өндөр үнээр удаан хугацаанд тээвэрлэдгээс хэрэглэгчдийг ХАА-н шинэхэн бүтээгдэхүүнээр хангах талаар Ази тивийн бусад бүс нутгаас хоцорч байна. Азийн бусад бүс нутагт энэ асуудал үндсэндээ шийдвэрлэгдээд байгаа билээ. Тухайлбал, Зүүн өмнөт Азид АСЕАН, Өмнөт Азид СААРК, Ази-Номхон далайн бүс нутагт АПЕК, ПЕКК зэрэг хамтын ажиллагааны эдийн засгийн иж бүрэн цогцолборууд үйлчлэлд нилээд удаж байгаа бөгөөд одоо үйлдвэрлэл, үйл ажиллагаа нь ч тогтворжиж, үнэ цэнэ нь харьцангуй хямдарч гагцхүү бүтээгдэхүүний чанарын үзүүлэлтээр уралдах чиглэлээр ажиллаж байна. Харин “хүйтэн дайн”-ы төгсгөлийн үе буюу 1980-аад оны Горбачёвын “шинэ сэтгэлгээний” бодлогоос гараагаа авсан Зөвлөлт-Хятадын харилцаа хэвийн болсоноор тухайлбал, сүүлийн 10-аад жилд ЗХА-ийн эдийн засгийн хамтын ажиллагааны асуудал зүй ёсоор өргөн дэвшигдэх болов. Энэ нь нэг талаас хөрөнгө, технологийн чадавхи бүхий Япон, Өмнөд Солонгос, нөгөө талаас байгалийн асар их нөөц, ажиллах хүчний илүүдэл бүхий Хятадын зүүн хойт хэсэг, Оросын Алс Дорнод, Монгол, Умард Солонгос гэсэн үйлдвэрлэлийг харилцан хорших иж бүрэн цогцолбор бүрдэх таатай нөхцөл байгаатай холбоотой юм. Тийм ч учраас тус бүс нутгийн хамтын ажиллагаа “Түмэн голын төсөл”, “Япон тэнгисийн хамтын ажиллагааны сав газар”, “Владивостокийн нээлттэй бүс” зэрэг олон хувилбараар хэлэлцэх болсон нь бүр ч сайшаалтай. Ялангуяа Японы Сасакава сангаас санхүүжүүлэн Америкийн “Дорно-Өрнө” төвөөс зохион явуулсан 1991 оны Чанчуны бага хурал, 1992 оны Владивостокийн бага хурал болон 1993 оны Улаанбаатарын бага

Х.Дашдондов - ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, эдийн засгийн ухааны доктор, профессор.

хурлууд нь ЗХА-ийн хамтын ажиллагааны асуудлын судалгааг өргөн хүрээгээр хамарч маш ул суурьтай явуулах сайхан боломж өглөө. Гэвч энэ бүс нутгийн хамтын ажиллагаа нь Европын хамтын нийгэмлэг “ЕЭС”, АСЕАН-ын орнуудынхтай агуулгаараа ойролцоо хэдий ч гэсэн хамтын ажиллагааны хэлбэр, зохион байгуулалт, үйл явц нь өвөрмөц онцлогтой юм. Учир нь энэ бүс нутгийн улс орнуудын оршин тогтнож буй орон зай, түүхэн хөгжлийн үйл явц, хүн амын зан заншил, эрэлт хэрэгцээ, үйлдвэрлэлийн арга технологи, техникийн түвшин, эдийн засгийн бүтэц, сонирхол нь харилцан адилгүйтэй холбоотой. Тухайлбал, ЗХА-ийн бүс нутгийн хойт хэсэгт орших Оросын Дорнод муж, Хятадын зүүн хойт муж болон Монгол улсад бүрэн ашиглагдаагүй байгаа өргөн уудам нутаг, мал аж ахуй эрхлэх өвөрмөц технологитой байхад Зүүн талын хэсэгт орших Япон, Умарт, Өмнөд Солонгост ХАА-н орчин үеийн өндөр бүтээмжтэй техник хөгжсөний дээр Орос, Япон, Хятадал ХАА-н түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийн орчин үеийн техник, технологи өндөр хөгжсөн нь тус бүс нутгийн хамтын ажиллагааны зохион байгуулалтын загвар нилээд өвөрмөц байхыг шаардаж байна. Хэрэв Зүүн хойт Азийн улс тус бүрийн үндэсний эдгээр давуу талуудыг хоршин ашиглаж чадвал ирээдүйд тус бүс нутаг нь ХАА-н бүтээгдэхүүнээр өөрийнхөө хэрэгцээг хангаад зогсохгүй, дэлхийн ХАА-н бүтээгдэхүүний импортод нилээд чухал байр эзлэх ч боломж байна. Ялангуяа бэлчээрийн мал аж ахуйн салбаруудыг далайцтай хөгжүүлж, өөрийн бүс нутгийн хүнсний хэрэгцээг хямд өртөгтэй химийн элдэв нөлөөлөлгүй, байгалийн цэвэр, чанарлаг бүтээгдэхүүнээр хангаад, бусад тив бүс нутагт ч экспортлох асах их чадавхи тус бүсэд байгааг анхаарах нь зүйтэй. Гэвч одоо үед байгаль, цаг уурын онцлогоос болж тус бүс нутгийн улс орнуудын хүн амыг зайлшгүй хэрэгцээт ХАА-н бүтээгдэхүүнээр хангах үйлдвэрлэлийн төрөлжилт, хоршилт хамтын ажиллагааны өндөр түвшинд хүрч чадаагүй байна. Жишээлбэл, хүн амын зайлшгүй хэрэгцээт цагаан будаагаар зэргэлдээ орших Японд 100% хангаж байхад бэйгаль, цаг уурын нөхцөлөөс болж уг бүтээгдэхүүнийг Монгол янз бүрийн зайд орших орнуудаас 100% импортоор авч байна. Мөн Монгол улс улаан буудайгаар 40% хэрэгцээгээ хангаж байхад Япон өөрийн үйлдвэрлэлээр уг бүтээгдэхүүний хэрэгцээний дөнгөж 17%-ийг хангаж, 80 гаруй хувийг АНУ, Канад мэт өөр тивд оршдог улсаас алс холын тээврээр импортлон авах жишээтэй. Ер нь хүнсний бүтээгдэхүүнийг алсын тээврээр холоос импортлох нь уг бүтээгдэхүүний үнийг өсгөж, чанарт муугаар нөлөөлөх нь зүйн хэрэг билээ. Нөгөөтэйгүүр цаашдаа 20-30 жилийн дараа дэлхийн хэмжээгээр ч, тив бүс нутгуудаар ч хүний тоо өсөж, хүнс, ХАА-н бүтээгдэхүүний хэрэгцээт шаардлага улам нэмэгдэх хандлагатай байна.

НҮБ-ын прогнозоор үзэхэд 1990 онд дэлхийн хүн амын тоо 5,3 тэрбум байсан бол 2000 онд 6,3, 2025 онд 8,5 тэрбум болох төлөвтэй байгаа бөгөөд тэр үед Азийн хүн ам дэлхийн бүх хүн амын 57,8 хувийг эзлэх болно. Тэгэхээр дэлхийн тив бүхэнд хүнсний бүтээгдэхүүнийг өсгөх шаардлага гарах бөгөөд түүнийг ХААҮ-ийг “эрчимт биш” ба “эрчимт” гэсэн хоёр аргаар шийдвэрлэх болно. Өөрөөр хэлбэл нэгдүгээр арга нь бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэхэд одоо тариалж байгаа талбайг тэлж тариалангийн эргэлтэнд атар газар эзэмших “эрчимт биш” замаар талбайг өргөтгөн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх буюу эсвэл химийн элдэв бордоог өргөн хэрэглэх замаар нэгж талбайгаас гарах ургацын хэмжээг нэмэгдүүлдэг хоёрдох “эрчимт” замыг хослуулан хэрэглэх шаардлагатай. Түүнчлэн мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний өсөлтийг ч мөн ийм л хоёр аргаар, тухайлбал, тоо толгойг нь өсгөн олшруулдаг “эрчимт биш” ба нэгж толгой малаас гардаг ашиг шимийнх нь гарцыг ихэсгэх “эрчимт” аргыг хослуулах жамтай. Гэтэл газар тариаланд тэнцэх үржил шимтэй атар газар ба малын бэлчээрт нэмж ашиглах бэлчээрийн талбай аль ч тивийн ихэнхи улсад хязгаарлагдмал учир “эрчимт биш аргаар” үйлдвэрлэл явуулах боломжгүй юм. Харин Ази тивийн зүүн хойд хэсэгт байгаа улсууд хөрөнгө хүчээ нэгтгэн хамтран ашиглаж чадвал газар тариалан, мал аж ахуйн аль ч салбарыг ямар ч аргаар хөгжүүлэх боломж бүхий газар нутагтай байна.

Газар тариаланд бордоо өргөн хэрэглэж, нэгж талбайн ургацыг нэмэгдүүлэхэд химижилтийн нөлөөлөл улам ихдэх бөгөөд малд ч мөн адил идэвхжүүлэх /стимулятор/ бодис хэрэглэх явдлыг хорогдуулах хандлагатай байгаа учир цаашид бас аль л болохоор бордоо хэрэглэхийг багасгах шаардлага гарах нь зайлшгүй. Тиймээс ойрын ирээдүйд хүнсний бүтээгдэхүүний тив хоорондын экспорт, импортын солилцоо бас л нилээд хязгаарлагдмал байдалтай болох хандлага аяндаа гарах болно. Үүнээс үндэслэж, тив бүс нутаг бүхэн өөр өөрсдийн дотоод нөөц бололцоондоо тулгуурлан хүнснийхээ бүтээгдэхүүний нэмэгдэх хэрэгцээг хангах эрэл хайгуул эхлэж байна. Энэ үед Азийнхан бидэнд ч бас л нөөцөө илрүүлэн ашиглах зохистой арга замыг эрэлхийлэх асуудал амин чухал болон тулгарах болно. Тэгэхээр тус бүс нутгийн улс орнуудын хөдөө аж ахуйн чадавхи боломж, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэгцээ, хэрэглээний хангамжийн өнөөгийн түвшин, хэтийн төлөвийг орон тус бүрийн онцлогтой уялдуулан авч үзэх шаардлагатай.

Нэг. Зүүн хойт Азийн ХАА хамтын ажиллагаанд  
хамаарагдах бүс нутаг

ЗХА-ийн ХАА-н салбар дахь хамтын ажиллагаанд хамаарагдах бүс нутагт Хятадын зүүн хойд хэсэг /Хар мөрөн муж, Гирын, Ляонинь, Шандунь, Хэбэй муж, Өвөр Монголын Өөртөө Засах Орон, /ӨМӨЗО/ болон Бээжин, Тяньжин хотууд/, Оросын Холбооны Улсын Алс Дорнодын район /Бүгд Найрамдах Саха/ Якут улс, Приморск, Хабаровскийн хязгаар, Амар, Камчаток, Магалан, Сахалин мужууд/ Монгол, БНАСАУ, БНСУ, Япон зэрэг 6 улсыг хамруулж байна.

Хамтын ажиллагааны энэхүү бүс нутагт хамрагдах эдгээр улсууд нь үйлдвэрлэл, технологийн өөр өөр түвшинтэй, газар нутаг, цаг уур, аж ахуйн хэв шинжийн хэлбэрүүд нь харилцан адилгүй учир хүн амын зайлшгүй хэрэгцээт ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өөр хоорондоо харилцан хорших, төрөлжүүлэн хөгжүүлэхэд хамтын ажиллагааг чиглүүлэх зорилготой юм. Энэхүү зорилт нь дараах бодит шаардлагуудаас урган гарч байгаа болно. Үүнд:

1. Хүн амын өсөлтийн хурдсаас хүнсний хэрэглээний хангамжийн түвшин хоцорч байгааг засах:

2. Хүн амын байнга өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангахад газар нутаг, цаг уурын таатай нөхцөл, аж ахуйг хөтлөх уламжлалт арга барил, зан заншил, эрт дээр үеэс хэвшин тогтсон дадлага туршлага ойролцоо бөгөөд түүнийг харилцан солилцох боломжийг бүрэн ашиглах:

3. Бүс нутгийн улс орнууд нэг тивд хөрш зэргэлдээ орших учир тээвэр холбоо, зам харилцаа зэрэг дэд бүтцийг нэгдсэн байдлаар үр ашигтай хөгжүүлэх:

4. Бүтээгдэхүүний тээвэрлэлтийн хугацаа, зардлыг эрс хорогдуулж, хүн амыг хүнсний шинэхэн хямд бүтээгдэхүүнээр хангах боломжийг улам нэмэгдүүлэх:

5. ХАА-н үйлдвэрлэлийг хоршуулж төрөлжүүлэхэд таримал ургамал, мал амьтдын төрөл, үүлдэр угсаа, уламжлын сангийн /генфонд/ хүрэлцээ бүхий нөөцийг өргөн ашиглах:

6. Бүс нутагтаа харилцан хөрөнгө оруулах, техник, технологи, ажиллах хүч харилцан солилцох асуудлыг өргөтгөх:

Эдгээр үндсэн нөхцөлүүдэд тулгуурлан Зүүн хойт Азийн бүс нутгийн хамтын ажиллагааг зохих ёсоор бүрэн хөгжүүлбэл Азийн хамгийн хангалуун амьдралтай нутаг энд л байх бүрэн үндэстэй.

### Хоёр. ЗХА-н хүн ам, хүнсний хангамж, эрэлт хэрэгцээ

ЗХА-д дээр дурьдсан хамаарагдах зургаан орны нилээд олон хүн оршин суудаг юм. 1990-ээд оны байдлаар БНХАУ-ын хүн амын бараг 1/4 хувь буюу 284,0 сая хүн, ОХУ-ын Алс Дорнодын районы 8,5 сая хүн амьдарч байгаагийн дээр Японы 123,5 сая, БНАСАУ 21,8, сая, БНСУ 42,8 САЯ, Монголын 2,4 сая хүн байна гэхэд энэхүү бүс нутагт нийт 482,8 сая хүн хамрагдаж байгаа бөгөөд энэ нь Азийн нилээд хүн ам амьдрах бүс болох юм. Жишээлбэл, Энэхүү бүсийн 1 квадрат км газарт ногдох хүний тоог авч үзэхэд зарим улс, тухайлбал, БНСУ-д 420, японд 325, БНАСАУ-д 166, хүн тус тус ноогдож байна. Цаашидаа 20-30 жилийн дараа улам их өсөх төлөвтэй. /1-р хүснэгтээс үз/.

#### ЗХА-ийн хүн ам /сая хүн/

#### Хүснэгт №1

	1990	1995	2000	2005	2010	2020	2025
1.ОХУ-ын Алс Дорнод*	8,5	8,8	9,0	9,3	9,5	9,9	10,1
2.ЗХ Хятад*	284	305	324	338	349	369	378
3.Япон	123,5	125,9	128,5	130,5	131	129	127,5
4.Өмнөд Солонгос	42,8	44,7	46,4	48,1	49,5	51,2	51,6
5.Хойд Солонгос	21,8	24	26	27,8	29,3	31,9	33
6.Монгол	2,2	2,5	2,8	3,2	3,6	4,4	4,8
Нийт бүсийн хүн	-	-	2,9	-	3,5	-	-
Амын дундаж өсөлт							
Тус бүсийн нийт Хүн ам	482,8	510,9	536,3	556,9	571,9	595,4	605

Жич: 2. ОХУ-ын Алс Дорнодын хязгаар, ЗХХ-ын тоо баримтууд нь баримжаагаар авч автор тооцоолсон тул ихээхэн хэлбэлзэлтэй байж болно.

НҮБ-ын прогнозоос үндэслэн тооцоолж үзэхэд 1990-2025 онд ЗХА-ын хүн ам 122,2 саяар буюу 25,2 % иар өсөх төлөвтэй байна. Энэ бол хүнсний бүтээгдэхүүнийг бас л тийм хэмжээгээр нэмэгдүүлэхийг шаардаж байна гэсэн үзүүлэлт юм.

ЗХА-ийн орнуудын хүн амын хэрэглээний хэмжээ, хүнсний бүтээгдэхүүний бүтэц, бүрэлдэхүүн нь оршин тогтнож буй орон зай, цаг уурын онцлог, хөдөлмөр эрхлэлт, хэрэглэж далсан зан заншлаас болж, харилцан адилгүй байдаг хэдий боловч хүний биеийн организмын хэвийн хөгжил, үйл ажиллагааг хангахад 3200 нэгжийн /элчлэгтэй/

калорийность/ бүтээгдэхүүн шаардагдахаас 40 орчим хувь нь мал амьтны гаралтай байх ёстойг орчин үеийн шинжлэх ухаан тодорхойлж байна.

Мөн уургийн /белок/ зүйлээс 60% нь амьтны гаралтай байхын дээр тослогийн 80-85 % нь мөн амьтны гаралтай байх шаардлагатай ба бусад нь ургамлын гаралтай байж болохоор тодорхойлсон байдаг. Гэтэл ЗХА-ийн аль ч улсад мал амьтны ба ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг шинжлэх ухааны үндэслэлтэй нормоор зохистой тэнцвэрээр хангах хэмжээнд үйлдвэрлэх нөхцөл бололцоо /улс бүхэнд/ байхгүй байна.

Тухайлбал, ЗХА-ийн орнуудын хүн амын хангамжийг хүний биеийн организмд зайлшгүй шаардагдах бүтээгдэхүүний элчиг чанараар авч үзэхэд БНХАУ-ын зүүн хойд хэсэгт 2641 ккал, ОХУ-ын Алс Дорнодын районд 3280, Япон 2921 ккал, БНАСАУ-д 2843, БНСУ-д 2826, Монголд 3250 ккал, байгаа нь дэлхийн ба Азийн дундаж үзүүлэлтээс нилээд дээгүүр байгаа хэдий боловч шинжлэх ухааны үндэслэлтэй нормын зохих түвшинд ихэнхи улсад хүрэхгүй байгаагаар барахгүй, бас хүний организмд зайлшгүй шаардагддаг уураг, тослог, нүүрс усны бүтцээр байвал зохих хэрэгцээг хангаж чадахгүй байгаад одоогоос онцгой анхаарч бүрэн хангах асуудлыг бүс нутгийн хэмжээнд шийдвэрлэх алсын хараатай эдийн засгийн нэгдсэн бодлого явуулах шаардлагатай байна.

### Гурав. ЗХА-ийн ХАА-н үйлдвэрлэлийн өнөөгийн байдал

ЗХА-ийн орнуудын ХАА-н үйлдвэрлэлийн салбаруудын хөгжлийн өнөөгийн түвшинг хүн амын хүнсний хангамжийн түвшинтэй харьцуулан үзэхэд улс бүрийн онцлогоос болж харилцан адилгүй байна. Энэ нь дээр дурьдсанчлан олон шалтгаанаас болж өөрийнхээ хүн амын хэрэгцээг улс орон бүр дотооддоо үйлдвэрлэх боломжгүйгээс ихэвчлэн өөр тив бүс нутгаас импортоор авч байгааг улс төр, эдийн засгийн харилцааны өөрчлөлтийн таатай нөхцөл өөрчлөн шинэчлэж, тив, бүс нутгийнхаа дотоод бололцоонд тулгуурлан шийдвэрлэх боломжтой болгожээ.

Уг асуудлыг шийдвэрлэхэд тус бүс нутаг тариалан, бэлчээр, хадлан, таримал тэжээлийн талбайг өргөтгөн ашиглах боломжтойн дээр ХАА-н түүхий эдийг бага зардлаар боловсруулан эцсийн бүтээгдэхүүн гаргах бололцоо ч байна. Жишээлбэл, ОХУ-ын Алс Дорнод, Хятадын хойд бүс нутагт үр тариа, техникийн таримал эрхлэх уудам их талбай бүхий нутгуудад өндөр ургац өгдөг сортууд тарьдаг технологитой

байхад Япон, Хятадын урд район, хойд, урд Солонгост тутаргын нутагшсан өндөр ургацын сортыг ихээр тариалах сайхан нөхцөл бүрджээ. Мөн Монгол улс ба Монголтой хил залгаа Хятадын ӨМӨЗО, бусад муж районууд болон ОХУ-ын Алс Дорнодын районуудад таван төрлийн малыг /үхэр, хонь, ямаа, адуу, тэмээ/ бэлчээрээр маллаж маш хямд үнэтэй, экологийн цэвэр мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүнийг ихээр үйлдвэрлэх нөхцөл бүрдсэн байх жишээтэй. ЗХА-ийн орнууд байгаль-цаг уурын нөхцөлөөс шалтгаалан хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн янз бүрийн салбарыг улс тус бүр өөр өөрсдийн онцлогт тохируулан хөгжүүлж ирсэн билээ. Гэхдээ өнөөг хүртэл тус бүс нутгийн орнуудын тэр онцлог нөхцөлүүдийг хоршин ашиглах боломж ч байгаагүй нь хэн бүхэнд тодорхой. Иймд цаашид бүс нутгийнхаа хүн амын хүнсний хэрэгцээг хангах чадавхи боломжийг ашиглах асуудлыг нарийвчлан судлах нь чухал бөгөөд үүнийг ярихын тулд юуны өмнө хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн өнөөгийн байдлыг улс тус бүрээр товч боловч авч үзэх нь чухал болно.

### 1. БНХАУ-ын Зүүн хойд район

БНХАУ нь ХАА, хөнгөн үйлдвэрлэлээрээ дэлхийд дээгүүр ордог улс билээ. Харин Хятадын зүүн хойд район нь ХАА-н үйлдвэрлэлээрээ нийт Хятадад их хувийг эзэлдэггүй ч Зүүн хойд Азийн хувьд ХАА-н томоохон бүс нутагт зүй ёсоор ордог. Одоогийн байдлаар л гэхэд ОХУ-ын Алс Дорнодын районд 2,9 сая га газарт газар тариалан эрхэлж байхад БНХАУ-ын ӨМӨЗО 7 сая га-д, Ляонинь муж 23 сая га-д, Гирин муж -42,8 сая га-д, Хар мөрөн муж-131.5 сая га-д тус тус газар тариалан эрхэлж байгаагаас хичнээн их нөөц бололцоотой нь илэрхий. Үүний зэрэгцээгээр эдгээр мужууд нь мал аж ахуйн хувьд тухайн бүс нутагтаа хамгийн их бололцоотой, бэлчээрийн, тэжээлийн аж ахуйн аль аль нь хөгжсөн нутгуудад зүй ёсоор орно. Тэгээд ч ӨМӨЗО одоо 55,5 сая толгой малтай/ гахайг оролцуулаад/, Ляонинь муж-21 сая, Гирин муж-10,7 сая, Хар мөрөн муж-14 сая малтай байна. Хятадын эдгээр мужуудын малын онцлог нь гэвэл гахайг махны чиглэлээр өсгөж буйн дээр хөдөө аж ахуйн, ялангуяа газар тариалангийн зүтгэх хүч болгон ашигладаг ажлын мал их байдаг.

Ерөнхийдөө зүүн хойд Хятад нь нийт Хятадад эзлэх газар тариалангийн үйлдвэрлэлээрээ /7-9%/ багавтар хувийг эзэлдэг ч гэсэн үр тарианы үйлдвэрлэл, ялангуяа улаан буудай, эрдэнэ шиш, буурцагт ургамлын ургац харьцангуй их хэмжээнд байдаг. Тухайлбал, ӨМӨЗО нь гэхэд жил тутам дунджаар 8 сая тонн үр тарианы ургац авдаг байхад Ляонин муж-15 сая тонн, Гирин муж-18 сая тн., Хар мөрөн муж-21 сая тн. үр тарианы ургацыг тогтмол хураадаг байна. Хэдийгээр үр тариа

эдгээр мужуудын ХАА-н бүтээгдэхүүний үндсэн хэсэг болдог ч мөн дагавар бүтээгдэхүүний чанараар төмс, хүнсний ногоо, манжин, чихрийн манжин, хөвөн, тослог ургамал тариалж дотоодын хэрэгцээг хангах үйлдвэрлэл явуулахын зэрэгцээ төрөл бүрийн туслах аж ахуйнуудыг хөгжүүлсэн байна. Үүний дотор бугын цусан эвэр, эмийн ургамлыг боловсруулж эм, бэлдмэлүүд гаргах, маалинга, тамхины ургамал тариалах, ойн бүтээгдэхүүнд ашиглах зэрэг чиглэлүүдээр хувийн, жижиг хоршоолуудыг ажиллуулж, өөрийн хэрэгцээг хангахаас гадна экспортын чиглэлээр ч үйлдвэрлэл явуулдаг байна. Хятадын эдгээр мужуудад далайн бүтээгдэхүүн ашиглахаас гадна, эх газрын цэнгэг усны нөөц бололцоог өргөнөөр ашиглаж, цэнгэг усны загасны аж ахуйнуудыг ажиллуулдаг сайхан туршлагатай. Зөвхөн Ляонин мужийн загасны аж ахуй жилд 1,1 сая тонн бүтээгдэхүүнийг нийлүүлнэ.

Мал аж ахуйн үндсэн бүтээгдэхүүн болох мал бэлтгэлээрээ Ляонин муж, хойд Хятадаа дээгүүр байр эзэлдэг. Үүнд: Зөвхөн нэг жилд тус мужаас мах бэлтгэлд нийлүүлдэг бүтээгдэхүүн буюу махны нийт үйлдвэрлэлийн хэмжээ 1,4 сая тонн-д хүрдгээс тодорхой байна.

Үүнээс үзэхэд зүүн хойд Хятадын бүс нутаг бол газар тариалан, мал аж ахуйн аль аль нь тэнцүү хөгжсөн бөгөөд өмнөд Хятадтай харьцуулбал хүн ам сийрэг, ХАА-н үйлдвэрлэлийн зохих бааз суурийг үүсгэж, үйлдвэрлэлийн хэмжээгээрээ Зүүн хойд Азийн бүс нутагтаа ихээхэн нөөц бололцоо бүхий нутагт орно. Үүгээрээ бүсийн хүнсний хангамж, ХАА-н үйлдвэрлэлийн хамтын ажиллагаанд жинтай байр суурийг эзлэх ёстой юм. Жишээлэхэд, энэ районд нийт Хятадын үр тарианы ургацын 7-10%-ийг, нийт төмсний ургацын 20%-ийг авч байгаагаас тодорхой.

Түүнчлэн Хятадын бусад бүсэд бага тархсан хонь, ямааны ихэнхи нь тус орны хойд, баруун хойд хэсэгт байдаг ажээ. Ялангуяа ӨМӨЗО өргөн уудам нутагтай учир бэлчээрийн мал аж ахуйг цаашид нилээд түлхүү хөгжүүлж, бүс нутгийн хамтын ажиллагаанд энэ чиглэлээр оролцох асар их боломжтой. Малын мах, сүүнээс гадна арьс, нэхий, ноос, ноолуур бэлтгэх нөөц бололцоотой.

Сүүлийн жилүүдэд Хятадад ХАА-н үйлдвэрлэлийн түргэн хөгжлийн үр дүнд хүн амын хүнсний хангамж эрс сайжирсан нь нэг хүнд ногдох хүнсний илчит чанар /калори/ 1961-63 онд хоногт 1658 ккал байсан бол 90-ээд онд 2641 ккал болж Азийн дундаж үзүүлэлтээс /2494 ккал/ давж, дэлхийн дундаж үзүүлэлтэд /2697 ккал/ дөхөж очжээ.

Хятадын гадаад худалдаанд экспортлогчийн том үүрэг гүйцэтгэж байдаг бүс нутаг нь Зүүн хойд район юм. Тэгээд ч бас Хятад улс жил бүр 6,9 сая тн. Улаан буудайг Аргентин, Австарли, Канад,



Франц, АНУ-аас, 2 сая тн. элсэн чихрийг Австарли, Куба, Филиппин, Тайланд зэрэг алс хол орших орнуудаас импортлож их зардал гаргаж, цаг хугацаа алдаж байгааг багасгахад энэ район, ЗХА-ийн бүс нутгийн хамтын ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэх нь дамжиггүй.

## 2. ОХУ-ын Алс Дорнодын район

Алс Дорнодын район /АДР/ нь 62 ,сая хавтгай дөрвөлжин км. нутагтай , түүний хойд хэсэг нь /Саха, Магадан муж/ 70 орчим хувь, Өмнөд хэсэг нь /Амур муж, Хабаровск, Приморскийн хязгаар/ 30 хувийг эзэлдэг боловч хүн амын 80% нь энд амьдардаг.

Тус районд үр тариа тариалах талбай 952,5 мянга га байгаа бөгөөд Амар муж, Приморск болон Хабаровскийн хязгаарт төвлөрч байна. 90-ээд онд жилдээ дунджаар 1114,7 мянган тн. үр тариа хурааж авсаны 58.7% нь Амар мужид, 31% нь Приморскийн хязгаарт ногдож байв.

Газар тариалангийн үйлдвэрлэлд шар буурцагийн тариалалт гол байр эзэлдэг бөгөөд ОХУ дахь түүний үйлдвэрлэлийн 90 орчим хувийг энд хураан авдаг.

Тус районы муж хязгаар бүрт түгээмэл тархсан таримал бол төмс юм. 90-ээд онд жилд дунджаар 1329.5 мянган тн, төмс хураан авсан бөгөөд районы хүн амын хэрэгцээг бүрэн хангаж байна. Мөн хугацаанд жилд дунджаар 465 мянган тн. хүнсний ногоо хураан авсан бөгөөд энэ нь районы нийт эрэлт хэрэгцээний 60 орчим хувийг хангаж байна. Үүний зэрэгцээ жилд дунджаар 182,8 мянган тн. үр жимс хураан авч байна.

Оросын Алс дорнодын район газар нутаг өргөн удам боловч мал аж ахуй харьцангуй бага хөгжжээ. 1990-ээд оны эхний байдлаар тус районд нийтдээ 1709,0 мянган үхэр, 1603,5 мянган гахай, 52,0 мянган хонь, ямаа байв. Тус районы хэмжээгээр 1990-ээд онд 336,1 мян.тн. мах, махан бүтээгдэхүүн, 1230,1 мянган тн. сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь районы хүн амын нийт хэрэгцээний 50 хувийг хангаж байв.

АДР-ны хойд хэсэг буюу Саха улсад /Якут/ цаа бутын аж ахуй хөгжүүлдгээрээ онцлогтой юм. Энд бас шувууны аж ахуй нилээд хөгжжээ. 1990-ээд оны эхний байдлаар 26,9 сая шувуу байсан бөгөөд жилд дунджаар 2,5 млрд. орчим өндөг авчээ. Энэ нь районы нийт хэрэгцээний 90 гаруй хувийг хангаж байв. Тус район хуучин ЗХУ-ын загас агнуурын 40 орчим хувийг эзэлж байлаа. Жилд 4,6 мянган тонн загас агнаж, 1,4 млрд. банк консерв үйлдвэрлэжээ. Нэг хүнд ногдох ХАА-н гол нэрийн бүтээгдэхүүний хэрэглээ өнгөрсөн 10 жилд хэрхэн өөрчлөгдсөнийг дараах хүснэгтээс харж болно.

ОХУ-ын АДР-ны нэг хүнд оногдож байгаа  
Хүнсний хэрэглээ /1980-1990/

(Хүснэгт №2)

	1980	1985	1990
Мах /амьдын жин/ кг	67	69	75
Сүү, кг	345	343	359
Өндөг ширхэг	276	285	304
Төмс	95	96	94
Гурил, гурилан бүтээгдэхүүн, кг	127	112	112
Загас, загасан бүтээгдэхүүн кг	30	31	32

Эх сурвалж: Дальний Восток России. Экон. ежегодник 1992, П часть с.287

Хүснэгтээс үзвэл 1980-1990 онд 1 хүнд ногдох мах 11,9, % сүү 4,18/% өндөг 10.1% загас, загасан бүтээгдэхүүн 6,6% тус тус өссөн байхад харин төмс, гурилан бүтээгдэхүүн багасчээ.

Гэтэл 1980 онд тус районы хүн ам 6910,7 мянга байсан бол 1991 онд 8056,6 мянга болж 16,5%-иар өсчээ. Үүнээс үзэхэд нэг хүнд ногдох ХАА-н зарим бүтээгдэхүүнээр өөрийн хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байгаа учраас тус район ОХУ-ын бусад районоос хүнсний зүйл авч байна. Гэвч Оросын ХАА-н үйлдвэрлэлийн гол районуудаас ихээхэн алслагдсан учир тээврийн зардал, хугацаа нэмэгдэж, бүтээгдэхүүний өөрийн өртөг өндөр болдог ажээ.

1992 оноос ХААҮ-ийн газруудыг шинэчлэх, өөрчлөх, зах зээлийн нөхцөлд зохицсон аж ахуйн шинэ хэлбэрүүдийг үүсгэн хөгжүүлэх ажил эрчимтэй явагдаж байна. Хамтрал, САА-уудыг задалж хувьчлах явцад тэдгээрийн суурин дээр фермерийн аж ахуй, янз бүрийн нөхөрлөлүүд, ХАА-н кооператив /хоршоолол/-ууд үүсэн хөгжиж байгаа бөгөөд эдгээрээс тооны хувьд фермерийн аж ахуйнууд илүү байна. Эдүгээ нэг фермерийн аж ахуйд ногдох газрын хэмжээ янз бүр байна. Тухайлбал, Камчаток муж, Якутын нэг аж ахуйд дунджаар 39-45га газар ногдож байхад Сахалин муж, Приморскийн хязгаарт нэг аж ахуй 13-17 га газар эзэмшиж байна. Фермерийн аж ахуй байгаль, цаг уурын нөхцөлөөр илүү тохиромжтой Амар муж, Приморск, Хабаровскийн хязгаарт илүү хурдан хөгжиж байна.

Оросын Алс Дорнодын районы ХАА-д фермерийн аж ахуй ихээхэн ирээдүйтэй болох нь өнгөрсөн 2 жилийн байдлаас харагдаж байна. Үүний зэрэгцээ хамтарсан, хувь нийлүүлсэн аж ахуйн хэлбэрүүд ч хөгжиж өрсөлдөх төлөвтэй.

Эдийн засгийн шинэчлэлийн явцад гадаад худалдааг либерилчилсан билээ. Ялангуяа импорт үндсэндээ чөлөөтэй болж,

зарим бүтээгдэхүүн, түүхий эдийн экспортод квот, лиценз олгож байна. Хүн амын хүнсний хангамжийг сайжруулах зорилгоор ХАА-н болон хүнсний бүтээгдэхүүний импортыг урамшуулж байна. Экспортын хувьд загас, загасан бүтээгдэхүүнд л лиценз олгож, ХАА-н болон хүнсний бусад бүтээгдэхүүнийг чөлөөтэй болгожээ. Энэ бүхнээс үзэхэд Оросын Алс Дорнодын районд зүүн хойд Азийн орнуудтэй ХАА-н талаар хамтран ажиллах ихээхэн боломж байна.

### 3. Япон улс

Япон улс байгаль, газар зүйн нөхцөлийн хувьд хөдөө аж ахуй эрхлэх боломжоор хязгаарлагдмал ч гэсэн орчин үеийн технологи, үйлдвэрлэл, хөдөлмөрийн зохион байгуулалтад тулгуурлан газар тариалан, жимс, ногоо, цэцэрлэгийн болон гахай, шувууны аж ахуйг богино хугацаанд хурдан хөгжүүлж чадсан юм.

Япон улсын 377,8 мян. хавтгай дөрвөлжин км газар нутгийн 70 орчим хувийг ой мод, уулархаг газар эзэлдэг учир тариалах талбайн хэмжээ бага, ердөө л 41,2 мян. хавтгай дөрвөлжин км байдаг. 1 хавтгай дөрвөлжин км -т газарт 325 орчим хүн ногдох бөгөөд хүн амын шигүү суурьшилтаар дэлхийд их өндөрт тооцогддог. Иймд өндөр хөгжсөн аж үйлдвэр, тээвэр, холбоо, шинжлэх ухаан, хөдөө аж ахуйг амжилттай хөгжүүлэх чухал нөхцөл нь болжээ.

Японы газар тариаланд цагаан будааны үйлдвэрлэл гол байр эзэлдэг. Тариалах талбайн дийлэнх хэсгийг цагаан будааны талбай эзэлдэг бөгөөд шинэ техник, технологи ашигласны дүнд 1 га-гаас авах ургацыг дунджаар 5,8 тоннд хүргэжээ. Ингэснээр цагаан будааны ургацын нийт хэмжээ ихээхэн өсч, 1990-ээд оны эхээр 12 сая тонныг /цэвэрлээгүй/ хураан авч байжээ. Тариалах талбай, дундаж ургац зэрэг үзүүлэлтүүдээс тооцож үзвэл Япон улс жилд 14 сая хүртэл тонн цагаан будаа хурааж авах боломжтой. Гэвч түүний эрэлт хэрэгцээ жилд дунджаар 10 гаруй сая тонн байдаг учир тэр хэмжээнд нь барих бодлого явуулдаг ажээ. Нэг хүнд ногдох цагаан будааны үйлдвэрлэлийн хэмжээгээр одоо дэлхийд дээгүүр байр эзлэж байна.

Цагаан будааны үйлдвэрлэл Засгийн газрын анхаарал хяналтанд байдаг, ашиг орлого ихтэй учир фермерүүд түүний тариалалтыг голлох болж бусад үр тарианы үйлдвэрлэл ихээхэн буурчээ. Тухайлбал, 1960 оны 1,5 сая тонн улаанбуудай, 2,3 сая тонн арвай хураан авч байсан бол 1991 онд харьцангуйгаар 860,0, 268,0 мянган тонн болж буурчээ. Буурцагт ургамлын тариалалт ч мөн хугацаанд бараг 2 дахин багасав. Үүний улмаас эдгээр үр тарианы дотоодын эрэлт хэрэгцээг өөрийн үйлдвэрлэлээр хангаж чадахгүй

болсон бөгөөд одоо тэдгээр нэр төрлийн бүтээгдэхүүнийг импортоор авч байна. 1991 онд гадаадаас худалдан авсан улаан буудай 124 тэрбум иенд хүрчээ. Гэхдээ Япон улс хүсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний хэрэгцээг аль болороор дотоод үйлдвэрлэлээр хангах чиг шугам баримталж байгаагийн үр дүнд ХАА-н бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэл хурдан өсөв. Тухайлбал, хүнсний ногооны нийт хэмжээ 1960 онд 11,7 сая тн байсан бол 1991 онд 15 сая тн. болж өсчээ. Үүнээс байцаа 3 сая тн, лууван 709,0 мянган тн, улаан лооль 770,0 мянган тн., сонгино 1,3 сая тн-ыг тус тус хураан авчээ.

Японд хамгийн их хэрэглэх дуртай мандарин, апельсин зэрэг жимсний үйлдвэрлэлийг өсгөх талаар Засгийн газраас зориуд анхаарч, тодорхой бодлого явуулсны дүнд 1960 онд 1,0 сая орчим тонныг хурааж авч байсан бол 1970 –аад оны үед 3,0 сая тоннд хүрч, зах зээлийн хэрэгцээг хэтрүүлэн хангасан юм. Иймээс Засгийн газраас зохицуулах арга хэмжээ авч үйлдвэрлэлийг нь нилээд бууруулжээ. Гэвч алимны тариалалтын хэмжээ олон жилийн турш нэг түвшинд /жилд дунджаар 1 сая тонн орчим/ хадгалагдаж байна.

Японд мал аж ахуйг хөгжүүлж, түүний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өсгөх талаар 1960-90 онд их амжилт олжээ. 1991 оны байдлаар 11,3 сая гахай, 335,0 сая тахиа, 4,8 сая үхертэй болжээ. Харин хонь, ямаа, адуу цөөн тоотой. Тухайлбал, 1991 онд 24,0 мянган адуу, 32,0 мянган хонь, 34,0 мянган ямаа байв.

1960-90 онд Япон улс үхрийн махны үйлдвэрлэлийг 4 дахин өсгөж 573,0 мянган тн, гахайн махыг 10,9 дахин өсгөж 1,5 сая тн, тахианы мах 12,6 дахин нэмэгдүүлж 1,4 сая тоннд тус тус хүргэжээ. Мөн өндөг 3,4 дахин нэмэгдэж 2,4 сая тн, сүү, сүүн бүтээгдэхүүн 4,2 дахин өсөж 8,1 сая тн-д тус тус хүрчээ. 1 үнээнээс жилд 6127 кг сүү сааж байгаа нь дэлхийд дээгүүрт орох үзүүлэлт юм. Хүн амын хүнсний хангамжийг дээшлүүлэхэд загасны аж ахуй чухал үүрэгтэй. Япон улс 1960 онд 6,0 сая тонн загас олзворлож байсан бол 1972 оноос 10,0 сая тн-д хүрсэн юм. Гэвч 1975 онд гадаад далайд 20 миллийн эдийн засгийн бүс тогтоосон явдал Японы загасны аж ахуйд хүнд цохилт болжээ. Япон улс АНУ, ОХУ, Канад, Шинэ Зеланд зэрэг улсуудтай хэлэлцээр хийж, тэдгээрийн эдийн засгийн бүсд тодорхой төлбөр төлж загас агнах болсон боловч жил ирэх тутам бэрхшээл ихдэж байна. 1990 –ээд онд жилд 13,0 сая гаруй тн. загас агнажээ.

ХАА-н үйлдвэрлэлийн хурдан өсөлтийн үр дүнд Япон улс гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр өөрийгөө хангах хэмжээг өндөр түвшинд хүргэжээ.

## Хүснэгт №3

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн	Дотоодын хэрэгцээг өөрийн үйлдвэрлэлээр хангах хувь /1990-ээд оны байдлаар/
Үр тариа	30
Цагаан будаа	100
Улаан будаа	17
Буурцагт ургамал	8
Хүнсний ногоо	91
Жимс	67
Өндөг	98
Сүү, сүүн бүтээгдэхүүн	76
Мах	73
Үүнээс: Үхрийн мах	58
Гахайн мах	77
Элсэн чихэр	34

Хүнсний хангамжийн бүтэц сайжирсны үр дүнд хоол хүнсний илчлэг чанар ихээхэн дээшлэв. Одоо хоногт 1 хүнд 2921 ккал, 95,1 гр. уураг, 81,2 гр. өөх тос ногдож байгаа нь дэлхийн болон Азийн дундаж үзүүлэлтээс нилээд дээгүүр байна.

Японы хүн амын өсөлт 1980 оноос хойш зогсонги байдалтай байв. Хэрэв 1980 онд тус улс 116782,0 мянган хүн амтай байсан бол 1990-ээд онд 123921,0 мянга болж, 6,1 %-иар өсчээ. Жилийн дундаж өсөлт 0,31-0,30% байна. Гэтэл ХАА-н бүтээгдэхүүний нийт хэмжээ 1980-83 онд нэг их өөрчлөгдөөгүй бөгөөд 1984-86 онуудад жилд дунджаар 6% өссөн юм. Харин 1987 оноос өсөлт буурсаар 1991 онд 1980 оныхоос 3,6 % багасчээ. Ялангуяа газар тариалангийн бүтээгдэхүүний хэмжээ бүр ч илүү /-6,8%/ буурав. Харин мал аж ахуйн бүтээгдэхүүн 1980-90 онд 17,4 % өсчээ. ХАА-н үйлдвэрлэлийн нийт өсөлт саарсаны улмаас нэг хүнд ногдох ХАА-н бүтээгдэхүүний хэмжээ бас буурав. 1991 оныг 1980 онтой харьцуулбал 9,2 % буурсан байна. ХАА-г хөгжүүлэхэд Японы төрийн зохицуулалт их үүрэг гүйцэтгэжээ гэж үзэх бүрэн үндэстэй. Үүнд: Нэгд. Японы ХАА-н түргэн хөгжил, түүний олсон амжилтын нэг чухал хүчин зүйл нь зах зээлийн механизмыг төрийн зохицуулалттай чадмаг хослуулсанд оршино. Үндэсний аюулгүй байдал, эрх ашгийг хамгаалах, хүн амын аж байдлыг дээшлүүлэх, хүнсний хангамжийг найдвартай болгоход чиглэсэн иж бүрэн арга хэмжээг Засгийн газрын зүгээс авч явуулсан байна. Тухайлбал, 1. Япон улс бэлчээр болон тариалах талбайн хэмжээ харьцангуй бага учир газрыг хамгийн зохистой ашиглахад онцгой анхаарчээ. Дэлхийн II дайны дараа газрын шинэчлэл хийж, эдэлбэр газрыг ганцхүү ХАА-н үйлвэрлэл эрхлэх хүмүүст

хуваарилж, түрээсээр өгсөн нь фермерийн аж ахуй хөгжихөд их түлхэц өгчээ.

Мөн цагаан будааг дотоодын хэрэгцээнээс илүү үйлдвэрлэж, гадаад гарган худалдах сонирхлыг багасгах бодлого явуулснаар бусад газрыг өөр чухал зориулалтаар ашиглах, юуны өмнө хүсний ногоо жимс жимсгэнэ, мал, гахай шувууны аж ахуй хөгжүүлэхэд зохистой хуваарилах боломжтой болгожээ.

Хоёрт. ХАА-н чухал нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд үнийн бодлогыг чадамгай ашигласан байна. Тухайлбал, Засгийн газар фермерүүдээс цагаан будааг өндөр үнээр /дэлхийн зах зээлийн үнээс 6 дахин их/ худалдан авч хэрэглэгчдэд хуваарилдаг учир түүний үйлдвэрлэл хурдан өсчээ. Нэгэнт цагаан будааны улсын үнэ ийм өндөр учир түүнийг ашигтайгаар экспортлох боломжгүй юм. Харин 1987 оноос цагаан будааны хэт үйлдвэрлэлийг хязгаарлахын тулд улсын худалдан авах үнийг өсгөхөө зогсоосноор барахгүй бүр 4,5 %-иар бууруулжээ.

Мөн үхрийн ба гахайн махны дотоодын үйлдвэрлэлийн зардалд үндэслэсэн үнийн тодорхой түвшин тогтоосон байна. Хэрэв зах зээлийн үнэ энэ түвшингээс доошоо байвал Засгийн газраас санхүүждэг. Мал аж ахуйн үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх корпораци, махыг их хэмжээгээр худалдан авч зохих нөөц бүрдүүлдэг бөгөөд зах зээл дээр үнэ тогтоосон түвшингээс дээш болмогц нөөцөлсөн махаа гаргаж борлуулдаг ажээ. Ийм аргыг сүүн бүтээгдэхүүний хувьд ч хэрэглэдэг байна.

Гуравт. Фермерийн жижиг аж ахуйг ХАА-н үндсэн нэгж болгон хөгжүүлэхийн тулд тэдгээрт газар, зээл, технологийн зэрэг бүх талын дэмжлэг үзүүлсэн байна. Үүний үр дүнд жижиг боловч их өндөр хөдөлмөрийн бүтээмжтэй аж ахуйнууд бий болжээ. Японы ХАА дахь хөдөлмөрийн бүтээмж 1990 онд 7254 ам.доллар болжээ. Энэ үзүүлэлтээр Япон улс Азид Сингалурын дараа II байрт орж байна.

Дөрөвт. ХАА-н гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дотооддоо хурдан хөгжүүлж, хүсний аюулгүй байдлыг хангахын тулд Засгийн газраас импортыг хязгаарлах бодлого явуулсан байна. Үүний үр дүнд 30-аад жилийн өмнө багаахан хэмжээтэй байсан гахай, тарианы болон хүсний ногоо, жимс жимсгэний аж ахуйг хөл дээр нь босгож, дэлхийн зах зээл дээр өрсөлдөх хэмжээнд хүргэжээ.

Японы ХАА-н гол салбарууд эдүгээ дэлхийн зах зээлд өрсөлдөх өндөр хэмжээнд хүрсэн учир ХАА-н бүтээгдэхүүний гадаад худалдааны хязгаарлалтыг цаашид багасгах чиглэл барьж байна. Энэ нь бүс нутгийн хүрээнд ХАА-н талаар хамтран ажиллах таатай нөхцөл бүрдүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ.

(Үргэлжлэл дараагийн дугаарт)